



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 08 сарын 29 өдөр

Дугаар A/305

Улаанбаатар хот

Г Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм, бутэц батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал (Н.Цогбадрах)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/310 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
08 сарын 29-ны өдрийн 1 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв (цаашид “Төв” гэх) нь зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдвартын эрсдэлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүрэг бүхий тусгай мэргэжлийн үндэсний төв мөн.
- 1.2. Төв нь Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгоно.
- 1.3. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.
- 1.4. Төв нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байгууллагын стратеги төлөвлөгөөг 4 жилийн хугацаатайгаар Эрүүл мэндийн сайдаар батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.5. Төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бэлгэдэл, тут, санхүүгийн харилцах дантай байна.
- 1.6. Төв нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 218 дугаар тогтоолын дагуу цагдаа, дотоодын цэргийн хамгаалалт бүхий Улсын онц чухал объект болно.
- 1.7. Төвийн албан ёсны хаяг: Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Монгол Улс, Улаанбаатар хот 18131, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо,  
Холбоо барих утас: 70282859,  
Цахим хуудасны хаяг: nczd.gov.mn  
Цахим шуудангийн хаяг: nczd@nczd.gov.mn байна.
- 1.8. Төвийн нэрийг англи хэл дээр “National Center for Zoonotic Diseases” гэж орчуулна.
- 1.9. Төв нь байгууллагын дотоод журамтай байна.
- 1.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, ялгavarлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### ХОЁР. Төвийн зорилго, зорилт, баримтлах зарчим

- 2.1. Алсын хараа: Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр Номхон далайн баруун бүсийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хамтын ажиллагааны төв байна.

2.2. Эрхэм зорилго: Шинжлэх ухааны шинэ дэвшилтэт технологи, инновацийг мэргэшсэн хүний нөөцийн чадавхтай хослуулан Монгол Улсын хүн амыг зоонозын өвчний эрсдлээс сэргийлэх.

2.3. Төвийн зорилт:

- 2.3.1. Шинжлэх ухааны дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, үндэсний хэмжээнд болон төвийн үйл ажиллагаанд өргөнөөр ашиглах;
- 2.3.2. Төвийн хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэргэжлийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;
- 2.3.3. Улсын хэмжээнд зоонозын өвчний эрсдлээс сэргийлэх, өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах;
- 2.3.4. Зоонозын халдвараас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, чадавхыг бэхжүүлэх.

2.4. Төв нь дараах зарчмыг баримтална:

- 2.4.1. Хууль, хүний эрхийг дээдлэх, ил тод байх;
- 2.4.2. Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
- 2.4.3. Ёс зүй, харилцаа хандлагыг эрхэмлэж, хариуцлагатай байх;
- 2.4.4. Хүний эрүүл мэнд, хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- 2.4.5. Авлига, албан тушаалын зөрчлөөс ангид байж, урьдчилан сэргийлэх;
- 2.4.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, удирдамжийг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд ханган ажиллах;
- 2.4.7. Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх;
- 2.4.8. Манлайлал, хөгжлийг эрхэмлэсэн суралцагч хамт олон байх.

## ГУРАВ. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй:

- 3.1.1. Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэлзүйн заавартай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.2. Шаардлагатай эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.3. Эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, чанар сайжруулах арга аргачлал, хэрэгслийг нэвтрүүлэн, тогтмолжуулан ажиллах;
- 3.1.4. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг бэхжүүлэх, алсын зайн сургалт зохион байгуулах;
- 3.1.5. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, ном товхимол, зөвлөмж заавар гаргах, хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох;
- 3.1.6. Олон улсын байгууллага, гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэж харилцан ойлголцлын санамж байгуулах;

- 3.1.7. Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүсгэж болзошгүй үед шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хувь хүнээс гаргуулах;
- 3.1.8. Аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, сээрэмжлүүлэг өгөх;
- 3.1.9. Мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих;
- 3.1.10. Иргэн болон байгууллагын буруутай үйлдлээс болсон эрүүл мэндийн байгууллагаас гарсан гэнэтийн зардлыг Монгол Улсын Иргэний хуульд нийцүүлэн буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
- 3.1.11. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор хүлээлгэсэн бусад эрх.

### **3.2. Төв нь дараах үүрэгтэй:**

- 3.2.1. Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдвартын эрсдэлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 3.2.2. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, шаардлагыг биелүүлэх, тайлагнах;
- 3.2.3. Улсын хэмжээнд зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжилийг тогтоож, эрсдлийн дагуу бүсчлэх;
- 3.2.4. Зоонозын өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах;
- 3.2.5. Зоонозын өвчнийг оношлох лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний мэдээлэл лавлагааны сан бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллага, олон нийт, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах;
- 3.2.6. Улсын хэмжээнд халдварт өвчний ариутгал, халдвартгүйжүүлэлт, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах;
- 3.2.7. Зоонозын халдвартын эсрэг вакцин, биобэлдмэл, оношуур, тэжээлт орчин, будаг урвалж шинээр бүтээх, нэмэгдүүлэх, турших биоүйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- 3.2.8. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед “Олон улсын эрүүл мэндийн дүрэм”-ийг баримтлан ажиллах, шаардлагатай ашиглах нөөцийг бүрдүүлэх, бүртгэх, хадгалалтын горимын дагуу хадгалах, зарцуулах үйл ажиллагааг холбогдох шийдвэрийн дагуу зохион байгуулах;
- 3.2.9. Барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх холбогдох хууль, стандартын шаардлагыг ханган ажиллах;
- 3.2.10. Албан хаагчдын нийгмийн баталгаа, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, мэргэжил үр чадварт тохирсон цалин хөлс олгох, ажлын бүтэээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, мэдлэг үр чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах;
- 3.2.11. Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хэвшил болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 3.2.12. Төвийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүртгэл тооллогыг тогтоосон хугацаанд хийх, данснаас хасах, шилжүүлэх, устгал хийх асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх;

- 3.2.13. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үндэслэл, тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулах, батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж, байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах;
- 3.2.14. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, хэрэгжүүлэх;
- 3.2.15. Үндсэн болон төсөвт хөрөнгийн ашиглалтын зарцуулалт, үр ашгийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл, нэгжүүдийн аж ахуйн тооцоо, байгууллагын орлого, зарлагын дотоодын хяналт, шалгалтыг тогтмолжуулах;
- 3.2.16. Төв нь үйл ажиллагаандаа авлига авах, өгөх, албан тушаалын тушаалын байдлаа аливаа хэлбэрээр урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох, урьдчилан сэргийлж ажиллах;
- 3.2.17. Жендерийн тэгш байдлыг хангах, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, хүний эрхэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллах;
- 3.2.18. Төвийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд шуурхай хариу өгөх, дун шинжилгээ хийж хэрэгжилтийг ханган ажиллах;
- 3.2.19. Эрүүл мэндийн багц хууль, тогтоомжийг нийтэд сурталчлах;
- 3.2.20. Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;
- 3.2.21. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүрэг.

#### **ДӨРӨВ. Төвийн удирдлага, зохион байгуулалт**

4.1. Төвийг захирал удирдана. Захирал нь гадаад, дотоод үйл ажиллагаанд Төвийг төлөөлнө.

4.2. Төвийн удирдлагын тогтолцоо нь Захирал, Дэд захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.

4.3. Төвийн захирал нь дэд захирал, нэгжийн удирдлага, Үйлдвэрчний эвлэлийн салбар зөвлөлийн төлөөлөл болон бусад төлөөллийг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4.4. Төв нь өөрийн эрхэлсэн салбар, чиг үүргийн хүрээнд эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулсан судалгаа, шинжилгээний ажлын чиглэл болон хэрэгжүүлж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөлийг байгуулан ажиллуулж болно Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн төвийн захирал батална.

4.5. Төв нь Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон бусад шаардлагатай чиг үүрэг бүхий байнгын, түр хороо, зөвлөл, ажлын хэсгийг байгуулах, мэргэжлийн асуудлаар зөвлөх ажиллуулж болно.

4.6. Төвийн захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын шийдвэр, тогтоол, тэмдэглэл гаргана.

4.7. Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь алба байна. Нэгжийн удирдлага нь тухайн албын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.

#### **ТАВ. ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ**

- 5.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
  - 5.1.1. Улсын төсөв;
  - 5.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилт;
  - 5.1.3. Үндсэн (хууль, тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусlamж, үйлчилгээний орлого) болон үндсэн бус (хууль, тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого гэх мэт) үйл ажиллагааны орлого;
  - 5.1.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусlamж;
  - 5.1.5. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
  - 5.1.6. Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
  - 5.1.7. Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.
- 5.2. Төв нь санхүүжилт, эд хөрөнгийг төвийн зорилго, зорилт, холбогдох хууль, тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулан ашиглаж, ил тод байдлыг хангана.
- 5.3. Төв нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө бүртгэлд авах, тэдгээрийг данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.4. Төвийн эд хөрөнгийн тооллогыг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.
- 5.5. Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэж, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.
- 5.6. Төв нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

#### **ЗУРГАА. Гадаад, дотоод хамтын ажиллагаа**

- 6.1 Төвийн захирлын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох болон орон нутагт ажиллах албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.2 Төвийн захирал нь албан хаагчдын гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.3 Төвийн захирал нь төрийн захиргааны төв байгууллагын Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль, тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа үүрэг, чиглэл, зөвлөмж авч үйл ажиллагаагааг уялдуулан ажиллана.
- 6.4 Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

## **ДОЛОО. Төвийн захирал, дэд захирлын эрх, үүрэг**

- 7.1. Төвийн захирлын эрх, үүрэг:
- 7.1.1. Эрүүл мэндийн бодлого, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдварын эрсдэлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх болон зоонозын өвчин судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж, төвийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн сайдын өмнө хариуцна.
- 7.1.2. Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, улсын хэмжээнд баримтлах бодлого чиглэл болон стандарт, журам, эмнэлзүйн заавар, тушаал, шийдвэр боловсруулахад оролцох, санал өгч хамтран ажиллана.
- 7.1.3. Төвийг бүрэн төлөөлөх бөгөөд үйл ажиллагааны, санхүүгийн, төсвийн гүйцэтгэл, эрүүл мэндийн статистик мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлэх, үнэн зөв байдлыг хариуцна.
- 7.1.4. Эрүүл мэндийн сайдаар жил бүр төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж, хэрэгжилтийг зохицуулан тайлagnах, ил тод мэдээлнэ.
- 7.1.5. Эрүүл мэндийн сайдын баталсан Албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээ болон Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг явуулж, түүний өмнө ажлаа хариуцан тайлagnана.
- 7.1.6. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилтийг оновчтой төлөвлөх, зарцуулах, хянах, ил тод байдлыг ханган ажиллана.
- 7.1.7. Салбарын санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний хүрээ, тоо хэмжээг төлбөрийн аргад суурилан төлөвлөх, цалин хөлсийг хууль, тогтоомжийн хүрээнд тогтооно.
- 7.1.8. Төвийн дэд захирал, нэгжийн удирдлага болон ажилтныг тухайн албан тушаалд тавигдах шаардлагад нийцсэн иргэдээс сонгон шалгаруулж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнэ.
- 7.1.9. Төвийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, эрсдэлийн удирдлагын болон хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд бусад дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолт батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээг цуцлах, хяналт тавина.
- 7.1.10. Албан хаагчдын мэдлэг боловсрол, ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 7.1.11. Холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ажилтны талаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ.
- 7.1.12. Төвийн үйл ажиллагааг сайжруулах санал, арга хэмжээний үр ашгийг тооцож, ашигтай хувилбарыг хэрэгжүүлнэ.
- 7.1.13. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшигийн бэлэн байдлын үед ажиллах байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо, гамшигийн шуурхай багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төлөвлөгөөг тухай бүр тодотгон батлуулж, шаардлагатай тохиолдолд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 7.1.14. Удирдах ажилтны болон салбар, мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, ажлын байрны дарамт, хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх, хориглох арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллана.

- 7.1.15. Авлигаас анgid байх, үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдал, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, урьдчилан сэргийлж ажиллана.
- 7.1.16. Манлайлал, эрүүл мэндийн болон бусад салбарын дэвшилтэт арга барил, хөгжлийн үр дүнтэй санаачилгыг дэмжиж, шинжлэх ухааны судалгаанд суурилсан үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлнэ.

7.2. Төвийн дэд захирлын эрх, үүрэг:

- 7.2.1. Төвийн дэд захирал нь захирлын шууд удирдлагад ажиллах ба Захирлын эзгүйд түүнийг орлоно.
- 7.2.2. Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдвартын эрсдэлийг бууруулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;
- 7.2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар, стандарт, аюулгүй байдлыг хангасан, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу хүртээмжтэй, аюул эрсдэлгүй, тасралтгүй хүргэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны үр дүнг хариуцан ажиллах;
- 7.2.4. Төвийн эмнэлзүйн үйл ажиллагааны хөгжлийн бодлого, тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, түүнтэй уялдсан хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, оношилгоо эмчилгээний шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх үйл ажиллагааг манлайлан ажиллах;
- 7.2.5. Чиг үүрэгт харьялагдах үйл ажиллагааг төвийн захирлын өмнө хариуцаж, тайлagnах;
- 7.2.6. Тусламж, үйлчилгээтэй холбоотой үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, сайжруулах санал, шийдвэрийн төслийг төвийн Захирал, Удирдлагын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;
- 7.2.7. Судалгаанд суурилсан үйлчилгээний шинэ туршлага, арга зүйг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;
- 7.2.8. Төвийн захирлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдал болон нэгжүүдийн уялдаа холбоог хангах, эмнэлзүйн үйл ажиллагаанд гарсан алдаа зөрчил, үл тохирлыг арилгах, зөвлөгөөн, хуралдааныг удирдан явуулах;
- 7.2.9. Харьяалах нэгжийн удирдлагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг үнэлэх, хагас жилээр үр дүнг төвийн захиралд тайлagnах;
- 7.2.10. Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг ханган, зохион байгуулах;
- 7.2.11. Үйлчлүүлэгчийн мэдээллийн хамгаалалт, нууцлалыг хангахад чиглэсэн эмнэлзүйн менежментийг хэрэгжүүлэхэд хяналт хийх;
- 7.2.12. Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах;
- 7.2.13. Авлигаас анgid, үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдлыг хангах, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хориглох арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах;
- 7.2.14. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт хууль, тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллах.

## **НАЙМ. Төвийн албадын ерөнхий чиг үүрэг**

**8.1. Захиргааны алба:** Төвийн алба, нэгжийн үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог хангах, хурал зөвлөгөөнийг зохион байгуулах, төлөвлөгөөний тайлагналт, хэрэгжилтэд хяналт тавих, хүний нөөцийн хөгжил, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, албан хэрэг хөтлөлт, албан хаагчдын нийгмийн хамгаалал, ажиллах орчин, хууль эрх зүйг мөрдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх үүргийг хэрэгжүүлнэ.

**8.2. Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба:** Зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжил, эрсдлийн түвшинг тогтоох, эрсдэлийн дагуу бүсчлэх, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар хангах, хүн амын дунд тандалт, судалгаа хийх, эрсдлийн түвшинг тогтоох хийх, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

**8.3. Лавлагаа лабораторийн алба:** Хүн амын дунд гарсан зоонозын өвчний шалтгаан, эх үүсвэрийг тодорхойлох, тохиолдлыг баталгаажуулах, лабораторийн тандалт хийх, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах, Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог, зэрэг сорьцыг баталгаажуулах, өсгөвөр зэрэг сорьцын сан бүрдүүлэх, баяжуулах, зоонозын өвчний онош зүйн лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана. Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтад хамрагдаж, сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага (MNS ISO/IEC 17025:2018)-ыг ханган ажиллана.

**8.4. Ариутгал, халдвартгүйтгэл, биоүйлдвэрлэлийн алба:** Зоонозын өвчин үүсгэгч бичил биетэн оношлох, оношуулур, биобэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, микробиологийн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэлийн үйлдвэрлэх, сүлжээ лабораторуудыг хангаж ажиллана.

### **8.5. Нөөц, бэлэн байдлын алба:**

8.5.1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглах эрүүл мэндийн салбарын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг гаргах, нөөцийг бүрдүүлэх, агуулахын удирдлагын систем ашиглан бүртгэх, хадгалах, зориулалтын дагуу зарцуулах, хадгалалтын байдалд тогтмол хяналт тавих, тооллого, тооцоо хийнэ.

8.5.2. Нөөцийн агуулах нь дараах үндсэн зорилго, чиг үүргийн хүрээнд ажиллана.

8.5.2.1. Нөөцийн агуулахад гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үссэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, вакцин биобэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, ариутгал халдвартгүйтгэлийн бодис, урвалж, оношуулурыг хадгалахаас гадна тайван цагт олон улсын байгууллагын хандив тусламжаар ирсэн болон улсын хэмжээнд нэгдсэн байдлаар худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийг хадгална.

8.5.2.2. Нөөцийн агуулах нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, тушаал шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулна.

8.5.2.3. Нөөцийн агуулахын үйл ажиллагаанд Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530: 2014 стандартыг мөрдөнө.

- 8.5.2.4. Нөөцийн агуулах нь “Эрүүл мэндийн яам, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах, Монгол Улс, Улаанбаатар хот 18131, Сонгинохайрхан дүүрэг, 20 хороо” гэсэн хаягтай байна.
- 8.5.2.5. Нөөцийн агуулахын нэрийг англиар “Medicines and medical devices reserve storage facility of the Ministry of Health and the National Centre for Zoonotic Diseases” гэж нэрлэнэ.
- 8.5.2.6. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэх, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үед шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд зарцуулагдах бэлэн байдлын нөөцийг энэхүү агуулахад төвлөрүүлнэ.
- 8.5.2.7. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ирүүлсэн стандартын шаардлагад бүрэн нийцсэн, чанарын баталгаатай багаж, тоног төхөөрөмж, хамгаалах өмсгөл, техник хэрэгсэл, эд хөрөнгөөр нөөцийг хангах арга хэмжээ авч, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтыг хариуцна.
- 8.5.2.8. Агуулахын үйл ажиллагаа, нөөц бүрдүүлэлт, хадгалалт, нөхөн хангалт, зарцуулалт хариуцсан орон тооны ажилчдыг төвийн захирал томилон ажиллуулна.
- 8.5.2.9. Агуулахын нөөц бүрдүүлэлт, хадгалалт, нөхөн хангалт, зарцуулалттай холбоотой бодлого зохицуулалт хийх шаардлагатай тохиолдолд Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газартай хамтран ажиллаж, хамтарсан шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлэх ба тогтмол мэдээлэл, солилцож ажиллана.

**8.6. Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн алба:** Зоонозын салбарт нэвтрэч буй олон улсын шинэ туршлага, инноваци, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах, энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийг хариуцах, эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах, сургалтын байгууллагуудтай хамтарч ажиллах, үндэсний төвийн мэдээллийн техник, технологийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хариуцаж, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, нууцлалыг хангах, шаардлагатай програм хангамжийн шийдлийг боловсруулж ажиллана.

**8.7. Чанар, аюулгүй байдал, хяналт, үнэлгээний алба:** Зоонозын өвчний тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, үйлчлүүлэгч, ажилчдын аюулгүй байдалд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх; халдвартын сэргийлэлт, хяналтыг бэхжүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх, ёс зүйн болон бусад хороо, зөвлөл, албадуудтай хамтран ажиллана.

**8.8. Санхүү, хангамж, үйлчилгээний алба:** Төвийн санхүү, эдийн засаг, төсвийн бодлогыг тодорхойлж шилэн дансны ил тод байдлыг хариуцах, байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг хууль, дүрэм, журмын дагуу явуулах, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, өдөр тутмын гүйлгээг хийх, бүртгэх, тайлагнах өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, бүртгэлийг хариуцаж, хөрөнгийн зүй зохистой харьцаа, үр өгөөжийг дээшлүүлж ажиллана.

### **ЕС. Бусад зүйл**

9.1. Энэхүү дүрэм нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Төвийн дүрэм хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээр төвийн нийт албан хаагчид дагаж мөрдөнө.

9.3. Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

---о0о---



## ЗООНЗОЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

